



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дөргөн сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/163-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2025 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: Н.Ариунтуяа Утас:70432545 Цахим хаяг: ariuntuyan@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2025.02.24 № 2/48
танай _____-ны № _____-г

ДӨРГӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.БАТТОГТОХ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дөргөн сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон арга хэмжээнд 9,143.0 мянган төгрөгийг зарцуулсан,
- Албан хаагчдад улирлын мөнгөн урамшууллыг 5,374.9 мянган төгрөгөөр илүү олгосон,
- ЗДТГ-ын эзэмших гэрчилгээтэй 9 нэгж талбарын 68449 м2 газрыг үнэлж данс бүртгэлд тусгаагүй,
- Тайлант онд 26,728.0 мянган төгрөг худалдан авсан шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналт сул, шатахуун олгох зөвшөөрлийн бичиг дугаарлаагүй, жолоочийн тооцоог бүрэн бодоогүй зэрэг зөрчлүүд байна

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын тогтоолоор төрийн захиргааны албан хаагчдад 5 жилийн мөнгөн урамшуулалд 23.0 сая, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад хөдөө орон нутгийн нэмэгдэлд 131.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс олгожээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд улс, аймаг, сумын хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүйгээр 274.4 сая төгрөг, орон нутгийн төсвөөр 56.6 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч бүртгэсэн байна.

Дөргөн сумын Засаг даргын тамгын даргын нягтлан бодох бүртгэлд тавих хяналт сул, түлээ нүүрс, шатахуун зарцуулалтын тайлангийн үнэн зөв байдал хангалтгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 бүлэг 5 зорилт 61 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнан сумын Засаг даргаар дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	41,147,010	63,736,571.91
33	АВЛАГА	2,230,830	2,646,842.11
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	120,554.11
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2,038,830	189,288
335	Бусад авлага	192,000	2,337,000
3351	Байгууллагаас авах авлага	-	2,145,000
3352	Хувь хүмүүсээс авах авлага	192,000	192,000
35	БАРАА МАТЕРИАЛ	38,916,180	61,089,730
351	Түүхий эд материал	1,246,800	2,941,800
35110	Тусгай зориулалттай материал	1,246,800	2,941,800
354	Хангамжийн материал	22,468,300	42,946,849.80
35410	Бичиг хэргийн материал	940,400	2,545,350
35420	Аж ахуйн материал	21,277,900	40,151,499.80
35470	Бусад хангамжийн материал	250,000	250,000
35600	Мал амьтад	15,201,080	15,201,080
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,645,632,188.04	2,724,190,890.61
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,645,632,188.04	2,724,190,890.61
392	Биет хөрөнгө	2,611,464,550.54	2,690,128,690.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,251,281,420	1,259,345,157
39202	Хуримтлагдсан элэгдэл	(800,463,777.84)	(857,271,738.16)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	262,244,999	299,744,999
39204	Хуримтлагдсан элэгдэл	(159,320,356.94)	(226,466,427.95)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	222,647,403	211,154,303
39206	Хуримтлагдсан элэгдэл	(161,884,062.40)	(141,603,886.19)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	66,673,128	83,075,678
39208	Хуримтлагдсан элэгдэл	(36,124,309.27)	(29,513,296.89)
39209	Зам, гүүрийн байгууламж	1,541,139,792	1,675,720,283
39210	Хуримтлагдсан элэгдэл	(96,892,958.31)	(151,750,870.14)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	800,000	800,000
39214	Бусад үндсэн хөрөнгө	973,707,076	1,089,514,796
39215	Хуримтлагдсан элэгдэл	(486,763,802.70)	(557,040,306.26)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	34,370,000	34,370,000
39217	Ном	50,000	50,000
393	Биет бус хөрөнгө	34,167,637.50	34,062,200.20
39301	Программ хангамж	2,302,000	2,302,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,076,562.50)	(2,181,999.80)
39303	Бусад биет бус хөрөнгө	33,942,200	33,942,200
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,686,779,198.04	2,787,927,462.52
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,641,078	1,641,078
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,641,078	1,641,078
413	Өглөг	1,641,078	1,641,078
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,641,078	1,641,078
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,685,138,120.04	2,786,286,384.52
51	Засгийн газрын хувь оролцоо	2,685,138,120.04	2,786,286,384.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	792,963,994	792,963,994
51101	Өмч: - төрийн	792,963,994	792,963,994
512	Хуримтлагдсан үр дүн	1,710,330,592.40	1,812,678,556.88
51210	Өмнөх үеийн үр дүн	1,710,330,592.40	1,702,865,908.87
51220	Тайлант үеийн үр дүн	-	109,812,648.01

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	181,843,533.64	180,643,833.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,686,779,198.04</u>	<u>2,787,927,462.52</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,139,639,973	1,388,783,489
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	521,675,610	318,239,295
120	Нийтлэг татварын бус орлого	521,675,610	318,239,295
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	521,675,610	318,239,295
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000	605,000
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	521,070,610	317,634,295
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	617,964,363	1,070,544,194
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	64,969,463	25,294,594
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,180,000	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,789,463	25,294,594
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	552,994,900	1,045,249,600
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	552,994,900	1,045,249,600
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	896,776,717.65	1,254,585,857.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	896,776,717.65	1,254,585,857.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	858,709,541.57	1,125,506,207.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	359,089,224.30	604,799,059.97
210101	Үндсэн цалин	359,089,224.30	359,585,069.00
210102	Нэмэгдэл	-	195,315,996.97
210104	Урамшуулал	-	27,061,324.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	22,836,670.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,317,349.80	75,944,009.44
210201	Тэтгэврийн даатгал	30,510,711.96	51,515,983.83
210202	Тэтгэмжийн даатгал	3,589,495.52	6,068,654.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,871,596.42	4,512,696.51
210204	Ажилгүйдлийн даатгал	663,350.94	2,183,941.80
210205	Эрүүл мэндийн даатгал	6,682,194.96	11,662,732.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,251,400.49	49,820,333.70
210301	Гэрэл, цахилгаан	3,571,400.49	12,776,533.70
210302	Түлш, халаалт	29,680,000	37,043,800
2104	Хангамж, бараа материалын зардал	40,115,073.33	45,861,456
210401	Бичиг хэрэг	3,667,200	5,442,600
210402	Тээвэр, шатахуун	33,778,540	25,089,406
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,597,333.33	2,812,750
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	72,000	12,516,700
2105	Нормативт зардал	209,000	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	209,000	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,506,650	4,757,200
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	810,000
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	100,000	-
210604	Урсгал засвар	7,406,650	3,947,200
2107	Томилолт, зочны зардал	4,772,000	7,938,000

210702	Дотоод албан томилолт	4,772,000	7,938,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,890,114	10,291,377.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,231,000	7,662,345.20
210803	Даатгалын үйлчилгээ	145,000	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	196,220	1,414,852
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,394	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,172,500	1,026,000
210807	Газрын төлбөр	123,000	188,180
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	363,558,729.65	326,094,771.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	103,034,923	90,407,896
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	175,000	292,000
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	260,348,807	235,394,875.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,067,176	129,079,649.78
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	327,273	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	327,273	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	960,000	24,107,491
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	23,047,491
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	960,000	1,060,000
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	36,779,903.08	104,972,158.78
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,779,903.08	104,972,158.78
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>242,863,255.35</u>	<u>134,197,631.79</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	24,384,983.78
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	398,999.78
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	23,985,984.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(24,384,983.78)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>242,863,255.35</u>	<u>109,812,648.01</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(ТӨГРӨГӨӨР)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>639,737,957</u>	<u>1,088,838,024</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,773,594	13,443,830
120	Нийтлэг татварын бус орлого	21,773,594	13,443,830
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	605,000	605,000
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000	605,000
120009	Бусад орлого	21,168,594	12,838,830
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	617,964,363	1,075,394,194
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	64,969,463	30,144,594
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,180,000	4,850,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,789,463	25,294,594
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	552,994,900	1,045,249,600

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	552,994,900	1,045,249,600
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	627,737,957	1,066,929,274
21	УРСГАЛ ЗАРДАЛ	627,737,957	1,066,929,274
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	587,809,223.92	937,120,336.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	358,657,219.19	607,075,399.12
210101	Үндсэн цалин	229,219,923.97	349,676,268
210102	Нэмэгдэл	85,068,598.22	205,464,397.12
210104	Урамшуулал	-	27,061,324
210105	Гэрээт ажлын хөлс	44,368,697	24,873,410
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,810,476.91	75,908,502.40
210201	Тэтгэврийн даатгал	29,429,973.25	51,685,526.16
210202	Тэтгэмжийн даатгал	3,175,619.77	6,077,308.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,768,969.43	4,849,383.71
210204	Ажилгүйдлийн даатгал	639,198.79	1,227,300
210205	Эрүүл мэндийн даатгал	6,796,715.67	12,068,983.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,578,673.49	49,820,333.70
210301	Гэрэл, цахилгаан	3,898,673.49	9,935,383.70
210302	Түлш, халаалт	29,680,000	39,884,950
2104	Хангамж, бараа материалын зардал	30,471,533.33	34,365,650
210401	Бичиг хэрэг	3,953,300	4,707,750
210402	Тээвэр, шатахуун	23,920,900	23,640,150
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,597,333.33	3,032,750
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	2,985,000
2105	Нормативт зардал	419,000	497,600
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	419,000	497,600
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,826,650	24,084,000
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	277,000	198,300
210604	Урсгал засвар	8,549,650	23,885,700
2107	Томилолт, зочны зардал	4,772,000	7,938,000
210702	Дотоод албан томилолт	4,772,000	7,938,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,609,714	18,477,858
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,950,600	15,852,326
210803	Даатгалын үйлчилгээ	145,000	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	196,220	1,610,352
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,394	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,172,500	827,000
210807	Газрын төлбөр	123,000	188,180
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	99,663,957	118,952,993
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	99,328,957	117,691,993
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	335,000	1,261,000
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,928,733.08	129,808,937.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,110,000	24,647,491
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	23,047,491
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,110,000	1,600,000

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	38,818,733.08	105,161,446.78
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,818,733.08	105,161,446.78
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	12,000,000	21,908,750
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	12,000,000	21,908,750
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,000,000	21,908,750
2200	Дотоод эх үүсвэрээр	12,000,000	21,908,750
222001	Тоног төхөөрөмж	12,000,000	21,908,750
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(12,000,000)	(21,908,750)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	792,963,994	181,843,533.64	1,689,551,499.49	2,664,359,027.13
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	9,269,700	9,269,700
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	792,963,994	181,843,533.64	1,698,821,199.49	2,673,628,727.13
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	11,509,392.91	11,509,392.91
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	792,963,994	181,843,533.64	1,710,330,592.40	2,685,138,120.04
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	792,963,994	181,843,533.64	1,710,330,592.40	2,685,138,120.04
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(7,464,683.53)	(7,464,683.53)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	792,963,994	181,843,533.64	1,702,865,908.87	2,677,673,436.51
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(1,199,700)	-	(1,199,700)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	109,812,648.01	109,812,648.01
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	792,963,994	180,643,833.64	1,812,678,556.88	2,786,286,384.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,046,624,600	940,882,441.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	982,224,600	918,973,691.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	927,903,200	894,326,200.22

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	613,670,000	607,075,399.12
210101	Үндсэн цалин	325,101,200	349,676,268
210102	Нэмэгдэл	247,797,100	205,464,397.12
210104	Урамшуулал	17,011,700	27,061,324
210105	Гэрээт ажлын хөлс	23,760,000	24,873,410
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,732,200	75,908,502.40
210201	Тэтгэврийн даатгал	52,185,400	51,685,526.16
210202	Тэтгэмжийн даатгал	6,136,700	6,077,308.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,909,400	4,849,383.71
210204	Ажилгүйдлийн даатгал	1,227,300	1,227,300
210205	Эрүүл мэндийн даатгал	12,273,400	12,068,983.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,941,200	49,820,333.70
210301	Гэрэл, цахилгаан	8,577,800	9,935,383.70
210302	Түлш, халаалт	53,363,400	39,884,950
2104	Хангамж, бараа материалын зардал	31,957,200	31,973,250
210401	Бичиг хэрэг	4,712,000	4,707,750
210402	Тээвэр, шатахуун	22,415,900	21,247,750
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,329,300	3,032,750
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000	2,985,000
2105	Нормативт зардал	553,700	497,600
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	553,700	497,600
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,884,000	24,084,000
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	317,000	198,300
210604	Урсгал засвар	3,567,000	23,885,700
2107	Томилолт, зочны зардал	8,105,600	7,938,000
210702	Дотоод албан томилолт	8,105,600	7,938,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,803,100	16,814,952
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,463,600	14,189,420
210803	Даатгалын үйлчилгээ	346,000	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,785,000	1,610,352
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	34,000	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	867,000	827,000
210807	Газрын төлбөр	307,500	188,180
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	115,256,200	80,214,163
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	113,772,200	78,953,163
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,484,000	1,261,000
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,321,400	24,647,491
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,321,400	24,647,491
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,544,900	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	23,102,000	23,047,491
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,674,500	1,600,000
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	64,400,000	21,908,750
2200	Дотоод эх үүсвэрээр	64,400,000	21,908,750
221001	Их засвар	5,000,000	-

222001	Тоног төхөөрөмж	59,400,000	21,908,750
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,046,624,600	940,882,441.22
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,046,019,600	940,277,441.22
132001	Орон нутгийн төсвөөс	1,046,019,600	940,277,441.22
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	605,000	605,000
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000	605,000
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	28	25
620001	Удирдах ажилтан	6	6
620002	Гүйцэтгэх ажилтан	13	10
620003	Үйлчлэх ажилтан	4	4
620004	Гэрээт ажилтан	5	5
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	28	25
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	7
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	7
650010	Гэрээт ажилтан	5	5
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6	6

ГУРАВ . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар нийт 370,935.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 327,569.2 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Үнэ төлбөргүйгээр ирсэн үндсэн хөрөнгийг орлогод аваагүй 131,880.0 мянган төгрөгөөр дутуу,
- Авлага 2,265.5 мянган төгрөгөөр дутуу,
- Өглөг 1,761.6 мянган төгрөгөөр илүү,
- Хөрөнгийн тайлант оны элэгдлийн зардлыг 625.0 мянган төгрөгөөр дутуу,
- Өмнөх онд малчдад худалдсан өвс тэжээлийн үнийг төлүүлэн санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй өмнөх үр дүн дансанд 9,269.7 мянган төгрөгөөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй,
- Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл, өмнөх оны хуримтлагдсан үр дүн дансны эхний үлдэгдлийг 41,558.2 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Акталсан хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг 1,199.7 мянган төгрөгөөр бууруулах бичилтийг орхигдуулсан,
- Үнэ төлбөргүйгээр бараа материалыг 7,304.5 мянган төгрөгөөр дутуу,
- Хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн үлдэгдлийг 16,734.4 мянган төгрөгөөр зөрүүтэй,
- Тайлант үеийн үр дүнг 114,970.6 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,

Залруулагдаагүй нийт 43,366.3 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 43,366.3 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрснээс, 7,424.9 мянган төгрөгийн төлбөрийн акт, 35,941.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Албан хаагчдад улирлын мөнгөн урамшууллыг журамд заасан хэмжээнээс илүү хувиар тооцон илүү олгосон, Засаг даргын нөөц хөрөнгөөс Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон мөнгөн аяга, бэлэг дурсгалын зүйл худалдан авахад нийт 7,424.9 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;"; Засгийн газрын Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна", Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20 -ны өдрийн 61 дугаар тушаалын хавсралтаар "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1-д " Нөөц хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулна."; 4.3-д "Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээний санхүүжилтийг эхний ээлжид нөөц хөрөнгөөс гаргана", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" гэсэн заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.2.1 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Засаг даргын нөөц хөрөнгөөс шинэ жилийн болон гарын бэлэг, дурсгалын зүйл худалдан авсан, хууль, журамд заагдаагүй 2025 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын зураг төсөв хийлгэх, ЭЕШ-д бэлтгэсэн сурагчдад сэтгэл санааны дэмжлэг, ЗДТГ-ын албан хаагчдад сэтгэл зүйг дэмжих, байгууллагын соёлыг нэвтрүүлэх сургалт зохион байгуулах зардалд нийт 7,093.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;"; Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар тушаалын хавсралтаар "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1-д " Нөөц хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулна."; 4.3-д "Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээний санхүүжилтийг эхний ээлжид нөөц хөрөнгөөс гаргана", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" гэсэн заалтуудыг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хуульд журамд заасан зардлыг санхүүжүүлэн, Төрийн хэмнэлтийн хуулийн холбогдох заалтыг мөрдөх

5.2.2 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Газрын нэгдсэн сангийн системд бүртгэлтэй ЗДТГ-ын эзэмших гэрчилгээтэй 9 нэгж талбарын 68,449 м² газрыг үнэлж данс бүртгэлд тусгаагүй зөрчил илэрсэн нь УСНББОУС-1, УСНББОУС31 Биет бус хөрөнгө АДБОУС 200,2000, MNS-6817-4:2020 стандартын 7.1.1.2.2, 7.1..3.4, 7.1.3.5 заалтууд болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны "Журам шинэчлэн батлах тухай" 271 дүгээр тогтоолын

3 дугаар зүйлийн 3.8-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь газар эзэмших эрх шинээр авах саналаа тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан, холбогдох Газрын алба, сумын газрын даамалд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ. Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газрын нэгдсэн системд бүртгэлтэй газруудыг данс бүртгэлд тусгах арга хэмжээг авч ажиллах

5.2.3. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 26,728.1 мянган төгрөгийн шатахуун худалдан авсан, тооцоог бүрэн бодоогүй, шатахуун олгох зөвшөөрлийн бичиг дугааргүй, шатахууны зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шатахууны олгох бичгийг оны эхнээс дугаарлах, сар бүр тооцоог бодох, шатахууны зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлэн ажиллах

5.2.4 Хувь хүний орлогын албан татвартай холбоотой асуудал

Илрүүлэлт: Өмнөх СТА-аар ХХОАТ-тай төлбөрийн акт бичигдэж төсвөөс 2,120.3 мянган төгрөгийг төлсөн, холбогдох байгууллагатай тооцоо нийлээгүй залруулах бичилт хийгдээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өмнөх онтой Татварын байгууллагатай тооцоо нийлж 2023 оны тайланд залруулга хийж үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах,

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв . Аудитаар илэрсэн буюу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мян.төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Запруулсан		Запруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Чандмань сумын ЗДТГазар	6	52,199.7	1	6,547.8	5	45,651.9	6	52,199.7	-	-
Дүн	6	52,199.7	1	6,547.8	5	45,651.9	6	52,199.7		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дөргөн сумын ЗДТГ	5	43,366.3	1	7,424.9			4	35941.4	-	-	-	-
Дүн	5	43,366.3	1	7,424.9	0	-	4	35941.4	-	-	-	-

ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	-	1	-	-		1	-	-
НИЙТ			1	-	-	-	1	-	-